



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 25 өдөр

Дугаар Б/Н/8

Хэрлэн сум

**Г.Ариунчимэгт нэг удаагийн буцалтгүй
тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.5 дахь заалт, Байгууллагын дотоод журмын 7.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн Гантөмөрийн Ариунчимэгийн өвөг эцэг нас барсан тул 150,000 (зуун тавин мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Буцалтгүй тусламжид зарцуулах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА